



Хорио цээрийн дэглэм гэж юу вэ?

Хорио цээрийн дэглэмийн үед КОВИД-19 халдварыг үүсгэгч SARS-CoV-2 вирус халдсан байж болох хүнийг бусдаас хол байлгадаг.

Тусгаарлана	<ul style="list-style-type: none"> Вакцин хийлгээгүй 	<ul style="list-style-type: none"> КОВИД-19 өвчний халдвар авсан хүнтэй хамгийн сүүлд харьцсаны дараа доод тал нь 5 хоног гэртээ байгаарай. Хэрэв танд шинж тэмдэг илрэхгүй бол 5 дахь хоногоос хойш хорио цээрийн дэглэмээ зогсоож болно. <ul style="list-style-type: none"> 5 дахь хоног эсвэл дараа нь та хорио цээрийн дэглэмийг дуусгахаасаа өмнө КОВИД-19 өвчний шинжилгээ өгөх хэрэгтэй. Хэрэв шинжилгээний хариу эерэг гарвал тусгаарлах зөвлөмжийг мөрдөнө үү. Шинжилгээ өгөх боломжгүй эсвэл шинжилгээ өгөхгүй гэж шийдвэл 10 дахь хоног дуустал хорио цээрийн дэглэм барих нь зүйтэй. Бусдын эргэн тойронд, ялангуяа өрөө тасалгаанд нийт 10 хоног сайн таарсан амны хаалт зүүгээрэй. (нэмэлт мэдээллийг доорх амны хаалт зүүх заавраас үзнэ үү.) Хэрэв танд шинж тэмдэг илэрвэл гэртээ байж, боломжтой бол шинжилгээ өгнө үү. Хэрэв та шинжилгээ өгч чадахгүй эсвэл хариу нь эерэг гарвал тусгаарлах зөвлөмжийг дагаж мөрдөөрэй.
ТУСГААРЛАХГҮЙ	<ul style="list-style-type: none"> Вакцин бүрэн хийлгэсэн Сүүлийн 90 хоногийн дотор өмнө нь КОВИД-19 өвчний халдвар авсан 	<ul style="list-style-type: none"> 5 дахь өдөр шинжилгээ өгнө. <ul style="list-style-type: none"> Хэрэв шинжилгээний хариу эерэг гарвал тусгаарлах зөвлөмжийг мөрдөнө үү. Ул хамаарах зүйл: Та КОВИД-19 өвчний халдвар авсны дараа 90 хүртэлх хоног шинжилгээ өгөх хэрэггүй. Бусдын эргэн тойронд, ялангуяа өрөө тасалгаанд 10 хоногийн турш сайн таарсан амны хаалт зүүгээрэй (нэмэлт мэдээллийг доорх амны хаалт зүүх зааварчилгаанаас үзнэ үү). Хэрэв танд шинж тэмдэг илэрвэл гэртээ байж, боломжтой бол шинжилгээ өгнө үү. Хэрэв та шинжилгээ өгч чадахгүй эсвэл хариу нь эерэг гарвал тусгаарлах зөвлөмжийг мөрдөнө үү. КОВИД-19 өвчний хүнд хэлбэр тархах их эрсдэлтэй гэж үздэг эсвэл эмзэг хүн амтай (жишээ нь асрамжийн газар, шорон, орон гэргүй хүмүүсийн байр) газар амьдардаг, ажилладаг эсвэл байнга очдог хүмүүс тус байгууллагын нэмэлт зааврыг дагах хэрэгтэй.


Тайлбар (22/4/18):

Аламеда тойргийн орон нутгийн эрүүл мэндийн байгууллага Калифорнийн Нийгмийн эрүүл мэндийн газар, Беркли хотын одоогоор баримталж буйгаас илүү нарийн чанд ӨХТ-ийн удирдамжийг мөрдсөөр байна. Дээрх удирдамжид Аламеда тойрогт тавьж буй хамгийн наад захын шаардлагыг тусгасан боловч халдвар дамжих эрсдэл 5 хоног өнгөрсний дараа байсаар байж болно. 10 хоногийн турш бусдаас хол байх нь хамгийн аюулгүй сонголт хэвээр байна.

Амны хаалт зүүх заавар:

Ойрын хавьтлын дараа 10 хоног өнгөртөл бусдыг хамгаалахын тулд сайн таарсан маск зүүх нь маш чуха. Амны хаалтыг хэрхэн хамгийн үр дүнтэй хэрэглэх талаар мэдээлэл авахыг хүсвэл энэ холбоосыг үзнэ үү.

<https://www.cdph.ca.gov/Programs/CID/DCDC/Pages/COVID-19/Get-the-Most-out-of-Masking.aspx>



**ALAMEDA COUNTY HEALTH CARE SERVICES AGENCY
PUBLIC HEALTH DEPARTMENT**

Colleen Chawla – Agency Director
Kimi Watkins-Tartt – Director
Nicholas Moss, MD – Health Officer

Contact
Public Health Department:
(510) 267-8000 Main Line
COVID-19 Information:
(510) 268-2101

www.acphd.org